

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар: А/39

Улаанбаатар хот

“Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын
журам”-ыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 8.3.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан Үндэсний давхар даатгал ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн “Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтын журам”-ыг батлах тухай 04/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Шинэчлэн батлагдсан журмыг оролцогч даатгагчид болон зуучлагч банкнуудад хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Андеррайтингийн газар /Т.Оюунбат/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ЭНХТАЙВАН

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТЫН ЖУРАМ Re

Нэг. Нийтлэг үндэслэл

УДААНБААТАР ХОТ
1119282186 ± 5885612

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Үндэсний давхар даатгал "Давхар даатгагч" гэх/ болон тусгай зөвшөөрөлтэй Малын индексжүүлсэн даатгалыг борлуулах гэрээ байгуулсан даатгалын компаниуд /цаашид "Даатгагч" гэх/, зуучлагч банкнууд /хамтад нь "Талууд" гэх/, түүний орон нутгийн салбар нэгжийн МИД-ын борлуулалтын үйл ажиллагаа явуулах, баталгаа болон борлуулалтын бүртгэл хөтлөх, түүнд хяналт тавих, алдаа дутагдлаас сэргийлэх, гарсан алдаа дутагдлыг засаж залруулах, борлуулалтын бүртгэл хөтлөлт, хаалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Иргэний хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд давхар даатгагч болон даатгагч, зуучлагчийн Баталгаа, борлуулалтын үйл ажиллагаа, борлуулалтын бүртгэл хөтлөхтэй холбоотой үйл ажиллагаанд мөрдөгдөнө.
- 1.3. Энэхүү журмыг давхар даатгагч болон даатгагч, зуучлагчид батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томьёоны тайлбар

- 2.1. "Малын индексжүүлсэн даатгал" /МИД/ гэж даатгалын тохиолдол бий болоход "Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль" болон Гэрээнд заасны дагуу нөхөн төлбөр төлөх даатгалын стандарт бүтээгдэхүүнийг;
- 2.2. "Давхар даатгагч" гэж Даатгалын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл авсан, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан малын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө, төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компанийг;
- 2.3. "Даатгагч" гэж Давхар даатгагчтай гэрээ байгуулж, МИД-ыг борлуулах эрх авсан даатгалын компанийг;
- 2.4. "Зуучлагч" гэж Даатгагчтай МИД-ыг зуучлан борлуулах гэрээ байгуулсан даатгалын зуучлагчийг;
- 2.5. "МИД-ын гэрээ" /цаашид "гэрээ" гэх/ гэж Даатгуулагч Баталгаанд бичигдсэн хураамж төлөх, Даатгагч нь Баталгаанд заасан тухайн малын сонгосон үнэлгээгээр даатгаж, даатгалын тохиолдол бий болоход Даатгуулагчид нөхөн төлбөр төлөх болон Даатгагч болон Даатгуулагчийн хоорондох МИД-тай холбоотой бусад харилцааг зохицуулсан гэрээг;
- 2.6. "МИД-ын баталгаа" /цаашид "баталгаа" гэх/ гэж Даатгуулагчийн ямар төрлийн малыг хэдэн төгрөгийн үнэлгээгээр сонгож, нийт хэдэн төгрөгийн даатгалын хураамж төлснийг баталгаажуулсан баримтыг тус тус ойлгоно.

Гурав. Гэрээ байгуулах, баталгаа бичих

- 3.1. Даатгагч нь тусгай зөвшөөрөл бүхий даатгалын төлөөлөгч, ажилтан, зуучлагчаар дамжуулан МИД-ын борлуулалтын хугацаанд давхар даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан гэрээний загварын дагуу МИД-ын бүтээгдэхүүнийг худалдан борлуулна.

- 3.2. Баталгаа нь Гэрээний хавсралт байх бөгөөд энэхүү журмын Хавсралт №1-ээр батлагдсан загварын дагуу 3 хувь хэвлэн ашиглана. Баталгаанд дугаар болон даатгагчийн нэрийг заавал бичнэ.
- 3.3. Даатгагч нь МИД-ын бүтээгдэхүүнийг борлуулахдаа даатгуулагчийн “А” дансны мэдээлэлд үндэслэн даатгана.
 - 3.1.1 Даатгалын төлөөлөгч нь даатгуулагчийн сонгосон үнэлгээнд үндэслэн хураамжийг үнэн зөв тооцож даатгана.
 - 3.1.2 Зуучлагч нь даатгалын хураамжийг тооцсон эрсдэлийн хэмжээнээс хамаарч нэг төрөл малыг 80,000, 150,000, 250,000, 350,000, 400,000, 500,000 төгрөгийн аль нэг ангиллаар сонгож даатгана.
 - 3.1.3 Зуучлагч нь даатгагчийн нэрийг заахгүйгээр МИД-ын бүтээгдэхүүнийг даатгагчидтай байгуулсан гэрээний хүрээнд нийт даатгагчдын нэрийн өмнөөс зуучлан борлуулна.
- 3.4. Даатгагч болон зуучлагч нь Гэрээ болон баталгааг алдаагүй, дэс дараалсан дугаарлалттайгаар хэвлүүлж бүртгэл хөтлөх ба хэвлэлтийн алдаанаас үүдэн гарсан хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.5. Гэрээ болон баталгаанд тусгасан мэдээллийг даатгагч, зуучлагч болон даатгуулагч нар өөрчлөх эрхгүй бөгөөд аливаа нэмэлт, өөрчлөлт нь хүчингүйд тооцогдоно.
- 3.6. Баталгааг зөвхөн даатгалын төлөөлөгч, зуучлагч ашиглах эрхтэй бөгөөд даатгагчид хоорондоо болон тусгай зөвшөөрөлгүй этгээдэд шилжүүлэн ашиглуулахыг хатуу хориглоно.
- 3.7. Гэрээг байгуулахаас өмнө даатгалын төлөөлөгч, зуучлагч гэрээний зүйл заалт болон МИД-ын талаар даатгуулагчид дэлгэрэнгүй тайлбарлаж ойлгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагч бүрэн мэдээлэлтэй болсны дараа гэрээг байгуулна.
- 3.8. Баталгаанд даатгуулагчийн талаарх мэдээлэл, харьяалагдах аймаг, сум болон даатгалын тооцооллыг бичихдээ цэвэр гаргацтай үнэн зөв бөглөнө. Даатгуулагчийн мэдээлэл, даатгалын тооцооллыг алдаатай бүртгэнээс үүдэн гарах аливаа хохирлыг гэрээ байгуулсан даатгагч эсвэл зуучлагч бүрэн хариуцна.
- 3.9. Даатгалын төлөөлөгч, зуучлагч нь даатгуулагчаас хураамж авч, гэрээ болон баталгаанд хоёр тал гарын үсэг зурснаар уг гэрээ, баталгааг хүчинтэй гэж үзэх бөгөөд дараах 3 этгээдэд тус тус хургуулнэ:
 - 3.9.1 Нэг дүгээр эх хувийг даатгагч, зуучлагчид;
 - 3.9.2 Хоёр дугаар хувийг даатгуулагчид;
 - 3.9.3 Гурав дугаар хувийг давхар даатгагчид.
- 3.10. Гэрээг байгуулахдаа даатгуулагчаас тухайн жилд МИД-д хамрагдсан эсэхийг сайтар нягтлах ба давхардуулан гэрээ байгуулж болохгүй.
- 3.11. Даатгагч, зуучлагчид нь нэг малчны аль нэг төрөл малыг давхардуулан даатгасан тохиолдолд хуанлийн 7 хоногт багтаж МИД-ын програмд бүртгэсэн бол баталгаан дээр бичигдсэн он, сар, өдөрт үндэслэн хугацааны хувьд түрүүлж байгуулсан гэрээг хүчинтэйд тооцно. Тухайн малчны нэг төрлийн малыг давхардуулан даатгасан гэрээний байгуулагдсан хугацаанаас хойш хуанлийн 7 хоногт багтаж МИД-ын програмд бүртгээгүй бол гэрээ байгуулсан огноог үл хамаарч тус гэрээг хүчингүйд тооцно. Хүчингүйд тооцсон борлуулалтыг МИД-ын програмын “Хүчингүй болсон төлөвт” бүртгэн даатгуулагчид даатгалын хураамжийг ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно.
- 3.12. Энэ журмын 3.11-д заасны дагуу Гэрээ хүчингүй болсон тохиолдолд даатгуулагчийн зөвшөөрлөөр өмнө нь даатгаснаас өөр төрлийн малыг нь даатгах боломжтой бол шинээр Гэрээ байгуулж, баталгаа бичиж болно.


Дөрөв. Баталгааг тараах, буцаан авах, бүртгэх

- 4.1. Даатгагч нь даатгалын төлөөлөгчдөд Баталгааг хуваарилж тараахдаа борлуулалтын төлөвлөгөө, тухайн даатгалын төлөөлөгчийн өнгөрсөн жилүүдийн борлуулалт хийсэн байдал, харьялагдах сумын малчин өрхийн тоо зэргийг харгалзан үзвэл зохино.
- 4.2. Даатгагчийн Баталгааг хуваарилсан бүртгэлийг МИД-ын програм хангамжийн "Хуудас олголт" цэсэд бүртгэнэ.
- 4.3. Баталгааг даатгалын төлөөлөгч хоорондоо шилжүүлэх тохиолдолд МИД-ын програм хангамжийн "Хуудасны шилжүүлэлт хийх" цэсийг ашиглан бүртгэл хөтөлнө.
- 4.4. Алдаатай, засвартай баталгаа илэрвэл энэхүү журмын 5.1-д заасны дагуу арга хэмжээг авна.
- 4.5. Борлуулалтын хугацаанд даатгагчийн орон нутаг дахь салбар нь даатгалын төлөөлөгчөөс хүлээн авсан баталгаа бүрийг дараах байдлаар эмх цэгцтэй, эрэмбэ дараалалтай бүртгэнэ:
 - 4.5.1. Даатгагч нь борлуулалт хийсэн баталгааг МИД-ын програм хангамжид бүртгэхдээ "МИД-ын борлуулалт" цэсэд борлуулалт хийгдсэнээс хуанлийн 7 хоногийн дотор бүртгэнэ.
 - 4.5.2. Даатгагч нь ашиглагдаагүй үлдсэн, хүчингүй болсон, хэсэгчлэн үрэгдүүлсэн баталгааны хувь тус бүрийг даатгалын төлөөлөгчөөс авч "Хуудасны төлөө хөтлөх" цэсэд бүртгэнэ. Ингэхдээ:
 - a) "Хүчингүй болсон төлөөт" буруу бичилт хийсэн, балласан, хураамжаа төлөөгүй болон баталгааны аль нэг, эсвэл хоёр хувийг үрэгдүүлсний улмаас хүчингүйд тооцсон баталгаануудыг хувь тус бүрээр нь бүртгэж, тайлбар бичнэ.
 - b) "Хаясан төлөөт" зөвхөн баталгааны гурван хувь гурвуулаа үрэгдэж байхгүй болсон бөгөөд дахин олдохгүй баталгааг бүртгэж, тайлбар бичнэ.
 - c) "Буцаан өгсөн төлөөт" ямар нэгэн бичилт хийгдээгүй, борлуулалтын хугацаа дуусаж илүү гарсан, гурван хувь бүрэн баталгаануудыг бүртгэнэ. Хэрвээ гэрээт баталгаанд давхар даатгагчийн зүгээс өөрчлөлт оруулахгүй бол буцаан өгсөн төлөөт бүртгэгдсэн баталгааг дараа жилийн борлуулалтын улиралд ашиглана.
- 4.6. Даатгагч болон зуучлагч нь борлуулалт хийгдсэн баталгааг төлөвөөр нь аймаг, сумаар нь ангилж, баталгааны дугаараар нь эрэмбэлнэ.

Тав. Баталгааны алдаа зөрчлийг залруулах

- 5.1. Даатгагчийн орон нутаг дахь салбар нь баталгаатай холбоотой илэрсэн алдаа зөрчлийг дараах байдлаар засаж залруулбал зохино:
 - 5.1.1. Даатгуулагчийн талаарх мэдээллийг алдаатай бичиж, засварласан тохиолдолд баталгааны 1, 2, 3-р хувь ижил засвартай, үнэн зөв эсэхийг шалгах ба хэрэв алдаатай бол баталгааны 1, 2, 3-р хувь дээр засаж бичнэ.
 - 5.1.2. Даатгалын тооцооллын алдааг дараах байдлаар залруулна:
 - а) Даатгалын төлөөлөгч хураамжийн хувь, малын төрлийг алдаатай, буруу бичсэн бол даатгуулагчаас асууж, алдаатай баталгааг хүчингүй болгож, дахин шинээр баталгаа бичнэ.
 - б) Малын дээд үнэлгээг буруу тооцсон тохиолдолд дээд үнэлгээг хувь тус бүр дээр засна. Хэрвээ даатгуулагчийн сонгосон үнэлгээ нь зассан малын дээд үнэлгээнээс давсан тохиолдолд уг баталгааг хүчингүй болгож, даатгуулагчтай зөвшилцэн шинээр баталгаа бичнэ.

Хуудас 3



- c) Даатгалын хураамжийг буруу тооцоолсны улмаас зөрүү дүн нь 1000 төгрөгөөс доош байвал төлсөн хураамжид нь тохируулан сонгосон үнэлгээг баталгаан дээр засаж, МИД-ын програм хангамжид бүртгэнэ. Зөрүү дүн нь 1000 төгрөгөөс дээш давсан тохиолдолд хүчингүй болгож, даатгуулагчтай зөвшилцэн дахин шинээр баталгаа бичнэ.
 - d) Нэгж малын үнийг буруу бичсэн тохиолдолд даатгуулагчийн сонгосон үнэлгээ нь малын дээд үнэлгээнээс хэтрэхгүй, даатгалын хураамжийн тооцоолол зөв бол шинээр баталгаа бичихгүйгээр засна. Нэгж малын үнээс хамаарч малын дээд үнэлгээ өөрчлөгднө, даатгуулагчийн сонгосон үнэлгээ нь малын дээд үнэлгээнээс хэтэрсэн тохиолдолд уг баталгааг хүчингүй болгож, даатгуулагчтай зөвшилцэн дахин шинээр баталгаа бичнэ.
- 5.1.3. Гэрээ зөрчсөн алдааг дараах байдлаар залруулна:
- a) Даатгагчийн төлөөлөгч даатгуулагчийн нэг төрлийн малыг хоёр удаа даатгаж давхардуулан гэрээ хийсэн тохиолдолд хамгийн эхэнд хийгдсэн гэрээг хүчинтэйд тооцно. Хүчингүйд тооцсон гэрээний хураамжийг даатгуулагчид буцаан олгож баталгааны 2-р хувийг даатгуулагчаас буцааж авна.
 - b) Хэрэв сүүлд байгуулсан гэрээнд тухайн төрлийн мал дээрээ өөр төрлийн мал нэмж даатгуулсан бол даатгуулагчтай зөвшилцэн зөвхөн нэмж даатгуулсан төрөл малыг нь даатгаж, дахин шинээр баталгаа бичиж болно. Энэ тохиолдолд зөрүү хураамжийн дүнг даатгуулагчид буцаан олгоно.
- 5.2. Даатгагч нь 5.1-д заасны дагуу илэрсэн алдаа зөрчлийг засаж, залруулан баталгаан дээрх "Хянан баталгаажуулсан" хэсэгт гарын үсэг зурж, баталгаажуулна.
- 5.3. Борлуулалтын явцад МИД-ын програм хангамжийн "МИД-ын жагсаалт" цэсээс баталгааг алдааны шалгууруудаар шүүж, илэрсэн алдаа зөрчлийг арилгана.

Зургаа. Борлуулалтын хаалт

- 6.1. Даатгагчийн орон нутаг дахь салбар нь даатгалын төлөөлөгчидтэй Баталгаа, хураамжийн орлогын тооцоог дуусгаж, баталгаа болон хураамжийн орлогыг програмын бүртгэлтэй давхар тулган, борлуулалтын хаалтыг аймгийн түвшинд 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүрэн дуусгасан байна.
- 6.2. Даатгагч болон зуучлагч нь борлуулалт хийсэн баталгаа, гэрээний нэг хувийг аймаг, sumaар нь ангилж, баталгааны дугаараар нь эрэмбэлэн давхар даатгагчид 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлнэ.
- 6.3. Даатгагч нь орон нутаг дахь салбарын МИД-ын програм хангамжийн Баталгааны бүртгэлийг шалгахдаа дараах мэдээллүүдийг хянан баталгаажуулсан байна:
- 6.3.1. Бүртгэгдсэн баталгааны тоо нь тухайн даатгагчийн орон нутаг дахь салбарт анх олгогдсон баталгаа болон нэмэлтээр авсан баталгааны тооны нийлбэртэй тэнцүү байх шаардлагатай.
 - 6.3.2. Баталгаа нь борлуулалт хийсэн, хүчингүй болсон, буцаан өгсөн болон хаясан төлөвүүд дээр бүртгэгдсэн байна. Борлуулалтын хаалт хийхэд олгогдсон, эсвэл шилжүүлсэн төлөв дээр бүртгэлтэй баталгаа байж болохгүй.
 - 6.3.3. Баталгааны 1 болон 2 хувь дутуу бол "хүчингүй" төлөвт бүртгэгдсэн байх ба "Хуудасны жагсаалт" цэсээс тухайн баталгааны дутуу хувь дээрх (✓) тэмдэглэгээг авсан байна. Харин баталгааны 3 хувь бүгд байхгүй тохиолдолд "хаясан" төлөвт бүртгэгдсэн байх шаардлагатай.
 - 6.3.4. Даатгагчийн зүгээс хүчингүй болсон, хаясан болон даатгалын төлөөлөгч даатгагчид хүлээлгэн өгөөгүй баталгааны хувь тус бурийг жагсаан тодорхойлолт гаргаж давхар даатгагчид хүргүүлнэ.

- 6.4. МИД-ын програм хангамжийн борлуулалтын бүртгэлийг шалгахдаа дараах мэдээллийг хянан баталгаажуулсан байна:
- 6.4.1. Даатгагч “МИД-ын жагсаалт” цэсийн алдааны шалгууруудаар илэрсэн зөрчлүүдийг холбогдох зааврын дагуу бүрэн арилгасан байна.
 - 6.4.2. Давхар даатгагч нь програмаас даатгуулагчийн нэг төрөл малыг давхардуулан даатгасныг шалгаж, энэ журмын 3.11 болон 5.1.3-т заасны дагуу холбогдох даатгагч, зуучлагчид мэдэгдэж залруулга хийлгэнэ.
 - 6.4.3. Даатгагч болон зуучлагч нь борлуулалтын тоо, даатгалын хураамж, даатгалын компанийн хөнгөлөлт болон даатгуулагчийн харьялал, холбогдох мэдээллийг нэг бүрчлэн шалгаж, алдаатай мэдээллүүдийг даатгуулагчаас асууж, баталгаажуулсны үндсэн дээр залруулна. Дээрх мэдээллүүдийг алдаатай бүртгэснээс үүдэн гарах аливаа хариуцлагыг гэрээ байгуулсан даатгагч, зуучлагч бүрэн хариуцна.
- 6.5. МИД-ын програм хангамжийн Хураамжийн орлогын бүртгэлийг шалгахдаа дараах мэдээллийг хянан баталгаажуулсан байна:
- 6.5.1. Борлуулалтын хаалт хийгдэхэд даатгагчийн дансанд төвлөрсөн хураамжийн орлогын дүн нь программын “Орлогын жагсаалт” цэсийн нийт дүнтэй тэнцүү байна.
 - 6.5.2. Давхар даатгагч болон даатгагч, зуучлагч бүртгэгдсэн баталгаа бүрийг тулгаж, борлуулалтыг хаана.
- 6.6. Борлуулалтын хаалт хийгдэхэд зуучлагчийн хураамжийн орлого нь программын “Банкны борлуулалтын жагсаалт” цэсийн нийт дүнтэй тэнцүү байна.


Долоо. Даатгагчийн эрх, үүрэг

- 7.1. Даатгагч нь өөрийн салбар нэгжтэй аймагт даатгалын төлөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулан МИД-ыг борлуулна.
- 7.2. Даатгуулагчтай Гэрээ байгуулсан буюу баталгаа үйлдсэн өдрөөс хойш хуанлийн 7 хоногийн дотор багтааж журмаар тогтоосон шаардлагатай мэдээллийг МИД-ын програмд оруулах үүрэгтэй.
- 7.3. Даатгагч, зуучлагч нь даатгуулагчийн нэг төрөл малыг давхардан даатгасан үед даатгалын төлөөлөгч гэрээ баталгааг зуучлагчаас урьтаж үйлдсэн боловч мэдээллээ энэ журмын 7.2-т заасан хугацаанд МИД-ын програмд оруулаагүй, хугацаа хожимдуулж оруулсан бол даатгалын төлөөлөгчийн баталгааг хүчингүй болгож, хураамжийг даатгуулагчид ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно.
- 7.4. Тухайн оны МИД-ын борлуулалтын улирал дууссаны дараа даатгагч нь тухайн аймагт даатгалын төлөөлөгчөөр борлуулсан МИД-ын борлуулалтын дунд үндэслэн хувь тэнцүүлэн зуучлагчаар борлуулсан багцыг хуваан авна.

Найм. Давхар даатгагчийн эрх, үүрэг

- 8.1. Давхар даатгагч нь даатгагч, зуучлагчад МИД-ын талаарх мэдээлэл, сургалтын материалыг бэлдэж өгнө.
- 8.2. Давхар даатгагч нь МИД-ын програм хангамжийг боловсруулж, хэвийн ажиллагааг ханган програмд оруулсан бүртгэлийг хянах үүрэгтэй.
- 8.3. Гэрээний оролцогч талуудаас МИД-ын борлуулалт, зуучлалтай холбоотой ирүүлсэн аливаа хүсэлт, гомдол, саналд цаг тухайд нь хариу өгнө.
- 8.4. Давхар даатгагч нь сар тутамд МИД-ын борлуулалтын мэдээг нэгтгэн холбогдож талуудад танилцуулна. Сар бүрийн эцэст авсан тайлангийн дүнгээр даатгагч болон

Хуудас 5



- зуучлагчийн давхардан даатгасан баталгааг шүүж оролцогч талуудад мэдэгдэж зөрчлийг арилгуулна.
- 8.5. Давхар даатгагч энэ журмын 7.4-д заасан зуучлагчийн багцаас даатгагчдад хуваарилах хувийг тооцоолно.
 - 8.6. МИД-ын борлуулалтын үйл ажиллагаа дуусмагц нийслэл болон бүх аймаг, сумдын МИД-ын зуучлалын борлуулалтын мэдээллийг нэгтгэсэн тайлан гаргана.
 - 8.7. Давхар даатгагчийн нэр дээр төвлөрсөн нийт МИД-ын хураамж нь тухайн оны МИД-ын борлуулалтын улирал дуустал давхар даатгагчийн дансанд байрших ба борлуулалтын хаалт хийгдэж дууссаны дараа давхар даатгагчийн тооцоолж, даатгагчийн нэхэмжилсэн дүнгээр даатгагчийн дансанд шилжүүлнэ.
 - 8.8. Даатгагч, зуучлагчийн зүгээс МИД-ын борлуулалтыг хийх явцдаа журмын заалтуудыг мөрдөж ажиллахгүй алдаа зөрчил гаргасан, харилцан бие биеийнхээ борлуулалтыг үндэслэлгүй цуцалсан тохиолдолд тухайн алдаа зөрчил гаргасан даатгагч, зуучлагчийн МИД-ыг борлуулах эрхийг цуцлах эрхтэй.

Ес. Хариуцлага

- 9.1. Давхар даатгагч, даатгагч болон зуучлагч нь энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд буруутай тал үүссэн хохирол, хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 9.2. Талууд өөрийн буруутай ажиллагааны улмаас давхар даатгагчийн МИД дээр баримталдаг бодлого, борлуулалтын болон зуучлалын үйлчилгээ үзүүлэхдээ энэхүү журамд заасан эрх үүргээ биелүүлээгүй нь баримтаар тогтоогдвол бусдад учруулсан аливаа хохирлыг бүрэн төлүүлэх арга хэмжээ авч ажиллана.
- 9.3. Энэхүү журмаар зохицуулсан харилцааг зөрчсөн тухай мэдээлэл, гомдлыг давхар даатгагчид бичгээр гаргаж, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлэх бөгөөд ирсэн гомдлыг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг талуудад бичгээр мэдэгдэнэ.
- 9.4. Давхар даатгагч энэхүү журам болон бусад холбогдох журмыг зөрчсөн, ёс зүйгүй ажилласан даатгагчийн ажилтан, төлөөлөгчид болон зуучлагчийн салбар нэгжийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах саналыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

--- о О о ---



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН БАТАЛГАА

Даатгалын компанийн нэр:

ДААТГАЛ

УЛААНБААТАР ХОТ

Даатгалын төлөөлөгчийн нэр:

Энэхүү даатгалын баталгааны ягаан өнгийн
(2-р) хувийг малчин өөртөө үлдээнэ.

Аймгийн нэр:

Сумын нэр:

Багийн дугаар:

Дааттулагчийн овог:

Даатгалын төлөөлөгч цагаан өнгийн (1-р)
хувь, шар өнгийн (3-р) хувийг өөрийн
харьялагдах даатгалын компанийд хүргүүлэх
үүрэгтэй.

Дааттулагчийн эцгийн нэр:

Дааттулагчийн нэр:

Дааттулагчийн яс үндэс:

Регистр №:

Дааттулагчийн утасны дугаар:

Дааттулагчийн банкны нэр:

Дансны дугаар:

Малын Индексжүүлсэн Даатгал (МИД)

Малын индексжүүлсэн даатгалын нехэн төлбөрийг даатгуулагчийн өмчлөлд буй малын хороодлын хэмжээг үл харгалзан, тухайн сумын малын хороодлын статистикийн албан ёсны мэдээ буюу дунд үндэслэн. Тухайн сумын малын хороодол босго үзүүлэлтээс давсан тохиолдолд нехэн төлбөр олгоно. Малын төрөл тус бүрийн хороодлыг МИД-ын гэрээнд заасны дагуу тооцно. Энэхүү баталгаа нь МИД-ын гэрээний салшгүй хэсэг болно.

	Малын төрөл	Хонь	Ямаа	Үхэр ба сарлаг	Адуу	Тэмээ	
1	Хураамжийн хувь					--	* Тухайн сумын малын төрөл тус бүрийн тоо толгой 5000-аас бага байх тохиолдолд хонин сүргийн хороодлоор төлөөлүүлэн нехэн төлбөрийг олгоно.
2	Даатгуулагчийн малын тоо						
3	Нэгж малын үнэ, төгрөгөөр						
4	Даатгагдах дээд хязгаар, малын үнэлгээний 100% (2 мөр * 3 мөр), төгрөгөөр						
5	Даатгуулагчийн даатгуулахаар сонгож буй малын үнэлгээ, төгрөгөөр						Нийт дун (төг)
6	Даатгалын хураамж, төгрөгөөр (1 мөр * 5 мөр / 100)						#
7	Даатгалын компанийн хөнгөлөлт						
8	Даатгуулагчаас төлөх нийт хураамж (6 мөр - 7 мөр), төгрөгөөр						

Даатгуулагч би энэхүү Малын индексжүүлсэн даатгал нь энэ оны жилийн эцсийн мал тооллоогоос дараа оны хагас жилийн мал тооллого хүртэлх хугацаан даахь зэрэлзлийг сумын малын хороодлын хувь хэмжээнд үндэслэн даатгаж нехэн төлбөр олохыг, мөн сумын малын хороодлын түвшин босго үзүүлэлтээс хэтрэгүй тохиолдолд нехэн төлбөр авахгүй болохыг хүлээн зөвшилцөр байна.

Би өөрийн өмчлөлийн малын тоог үнэн зөвхөөр мэдүүлсэн болохыг баталж байна.

Дааттулагчийн гарын үсэг:

.....онкарөдөр

Даатгагч би даатгалын ач холбоогдлыг малчдад үнэн зөвхөөр мэргэжлийн түвшинд ойлгуулах үүрэгтэй. Би даатгуулагчаас авсан хураамжийн орлогыг компанийн дансанд тушваж, даатгалын баталгааны цагаан, шар өнгийн (1,3-р) хувь, хураамжийн баримтыг тус бур өөрийн даатгалын компанийд борлуулалт хийснээс хойш ажлын 10 хоногийн дотор буюу борлуулалтын улсралын хугацаа дусгасвар болох 6-р сарын 30-ны өдрөөс хойш 7 хоногийн дотор хулээлгэн өгөх үүрээ хулээж байна.

Даатгалын төлөөлөгчийн гарын үсэг:

.....онкарөдөр /тамга/

Хянан, баталгаажуулсан Даатгалын
компаний салбарын захирал:

.....онкарөдөр